



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ТОГТООЛ**

2022 оны 01 сарын 20 өдөр

Дугаар 24

Улаанбаатар хот

**Үндсэн хөрөнгө акталж, данснаас хасах  
зөвшөөрөл олгох тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 6.4.3, 6.5, 6.6, 6.7 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1."Хархорин-АЗЗА" төрийн өмчит хувьцаат компанийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, 9,759,923.00 (есөн сая долоон зуун тавин есөн мянга есөн зуун хорин гурван) төгрөгийн балансын үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж, данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2."Хархорин-АЗЗА" төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал Ж.Бадрахад дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Байгууллагын Өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан хөрөнгийг акталж, данснаас хасах, хоёрдогч түүхий эд болгон ашиглах буюу сэлбэгээр худалдах ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3.Арга хэмжээний биелэлтийг 2022 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3.Акталж данснаас хассан тээврийн хэрэгслийн улсын дугаарыг хураан авч, улсын бүртгэл болон татвар төлөгчийн бүртгэлээс хасаж биелэлтийг ирүүлэхийг Автотээврийн үндэсний төв" төрийн өмчит үйлдвэрийн газрын захирал Б.Гүрсоронзонд даалгасугай.

4.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,  
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

Төрийн өмчийн бодлого,  
зохицуулалтын газрын 2022  
оны 01 дүгээр сарын 10-ны  
өдрийн 4 дугаар  
тогтоолын хавсралт

**"Хархорин-АЗЗА" ТӨХК-ийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, акталж данснаас  
хасах хөрөнгийн жагсаалт**

Д/д	Хөрөнгийн нэр	Үйлдвэрлэсэн/а шиглалтад орсон огноо	Тоо хэм жээ	Балансын үнэ (төгрөгөөр)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөгөөр)	Үлдэгдэл өртөг (төгрөгөөр)
1	Камаз-5511 маркийн, 15-13 ӨВА улсын дугаартай, ачааны машин, арлын дугаар- VO337625	1989/1990	1	9,759,923.00	9,759,923.00	0
	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>			9,759,923.00 (есөн сая долоон зуун тавин есөн мянга есөн зуун хорин гурван)	9,759,923.00 (есөн сая долоон зуун тавин есөн мянга есөн зуун хорин гурван)	